

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тавантолгой ХК 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2024/18/НА-СТА-ТӨА

Цахим хуудас:  
[www.Umnuqovi@audit.mn](http://www.Umnuqovi@audit.mn)

Өмнөговь аймаг  
2024 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр  
Утас: 70533539 Цахим хаяг: [Usukhbayarts@audit.gov.mn](mailto:Usukhbayarts@audit.gov.mn)  
Аудитын менежер: Т.Хонгорзул  
Утас: 70533552 Цахим хаяг: [Khongorzult@audit.gov.mn](mailto:Khongorzult@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Ж.Болормаа  
Утас: 70533552 Цахим хаяг: [Bolormaaja@audit.gov.mn](mailto:Bolormaaja@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



### ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2024.05.22 № 295

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ТАВАНТОЛГОЙ ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ  
Ч.ГҮНЖДАГВА ТАНАА

#### Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Тавантолгой ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн нотолсны улмаас Тавантолгой ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар борлуулалтын орлого дутуу бүртгэсэн, өглөг, авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, шатахууны норм хэтрүүлэн зарцуулсан, хөрөнгийг шууд зардалд бүртгэсэн, цалин, нэмэгдэл илүү олгосон, нэмэлт гэрээ байгуулсан, гэрээний хэрэгжилт тооцоогүй, шууд болон гэрээ байгуулаагүй худалдан авалт хийсэн, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээ хийсэн, өмнөх оны санхүүгийн тайланг программаар гаргаагүй, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн хүрээнд зохион байгуулаагүй зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай, Компанийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Төрийн аудитын тухай хуулийн холбогдох заалтууд болон НББОУС-1 "Санхүүгийн тайлангийн толилуулга" стандартад нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, тохиолдсон байх, үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх, толилуулга, ангилал, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Бизнес төлөвлөгөөнд орлогыг 1,250,029.1 сая төгрөг, зардлыг 1,055,529.6 сая төгрөг байхаар баталж, санхүүгийн тайланд 1,097,362.9 сая төгрөгийн орлого бүрдүүлэн,

016020509

592,432.9 сая төгрөг зарцуулж, 375,859.5 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан гэж тайлагнасан байна.

#### **Аудитын гол асуудал**

Төрийн аудитын газраас 2022 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан тул компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр "Гэрэлт хөхийн тэнцвэр аудит" ХХК-тай "Санхүүгийн тайлан баталгаажуулах" гэрээ байгуулан, дүгнэлт гаргуулж ажилласан байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Төсвийн тухай хуулийн цаглаварт хугацаанд өргөн цар хүрээг хамруулан аудитыг гүйцэтгэх боломжгүй тул зарим асуудлыг дараагийн аудитаар анхаарах асуудалд тусгасан.

#### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>	-	-
1.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	408,542,723,599.41	718,428,614,942.77
1.1.2	Дансны авлага	24,449,480,163.79	65,920,588,194.87
1.1.3	Татвар, <b>НДШ</b> - ийн авлага	162,990,448.19	438,833,228.20
1.1.4	Бусад авлага	107,803,162.45	43,910,793.90
1.1.6	Бараа материал	5,313,772,401.55	35,908,436,551.62
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,152,329,292.00	12,958,640,738.01
1.1.8	Бусад санхүүгийн хөрөнгө	23,220,000.00	19,770,000.00
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>439,752,319,067.39</b>	<b>833,718,794,449.37</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	15,786,447,878.55	20,895,059,846.13
1.2.2	Биет бус хөрөнгө	1,119,666,243.95	6,322,801,239.42
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	434,179,457.49	434,179,457.49
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>17,340,293,579.99</b>	<b>27,652,040,543.04</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>457,092,612,647.38</b>	<b>861,370,834,992.41</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	1,538,363,012.64	7,285,146,072.37
2.1.1.2	Цалингийн өглөг	398,944,729.34	8,083.66
2.1.1.3	Татварын өр	94,624,872,661.58	282,406,987,651.93
2.1.1.4	НДШ-ийн өр	99,999.92	
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүгийн өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	658,515,350.94	658,515,350.94
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	40,924,654,332.98	160,739,640,528.70
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		1,353,517,164.38
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>138,145,450,087.40</b>	<b>452,443,814,851.98</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>		
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>138,145,450,087.40</b>	<b>452,443,814,851.98</b>

<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч: - төрийн	48,188,698.49	48,188,698.49
2.3.2	хувийн	46,298,945.60	46,298,945.60
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	468,414,309.00	5,876,231,609.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	318,384,260,606.89	402,956,300,887.34
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>318,947,162,559.98</b>	<b>408,927,020,140.43</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>457,092,612,647.38</b>	<b>861,370,834,992.41</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>765,561,741,483.96</b>	<b>1,094,131,211,392.88</b>
2	Борлуулалтын өртөг	357,905,526,281.83	216,473,677,251.22
<b>3</b>	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>407,656,215,202.13</b>	<b>877,657,534,141.66</b>
5	Хүүгийн орлого	762,375,621.32	1,080,208,252.95
8	Бусад орлого	225,789,872.24	2,151,531,351.12
9	Борлуулалт маркетингийн зардал		355,531,258,389.05
10	Ерөнхий ба удирдлагын зардал	4,839,881,770.94	3,835,602,899.21
11	Санхүүгийн зардал		996,904.44
12	Бусад зардал	3,534,689,438.29	15,600,305,930.42
14	Гадаад валютын ханшийн зөрүүний олз/гарз/	33,538,691,680.26	(991,110,540.99)
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал)</b>	<b>433,808,501,166.72</b>	<b>504,929,999,081.62</b>
<b>19</b>	<b>Орлогын татварын зардал</b>	<b>107,628,362,853.81</b>	<b>129,070,544,963.08</b>
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>326,180,138,312.91</b>	<b>375,859,454,118.54</b>
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>326,180,138,312.91</b>	<b>375,859,454,118.54</b>

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2022 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл</b>	<b>94,487,644.09</b>	<b>468,414,309.00</b>	<b>59,768,404,359.48</b>	<b>60,331,306,312.57</b>

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			(54,015,533,192.50)	(54,015,533,192.50)
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>94,487,644.09</b>	<b>468,414,309.00</b>	<b>5,752,871,166.98</b>	<b>6,315,773,120.07</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			326,180,138,312.91	326,180,138,312.91
Зарласан ногдол ашиг			(13,548,748,873.00)	<b>(13,548,748,873.00)</b>
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	94,487,644.09	468,414,309.00	318,384,260,606.89	318,947,162,559.98
<b>2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>94,487,644.09</b>	<b>468,414,309.00</b>	<b>318,384,260,606.89</b>	<b>318,947,162,559.98</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			375,859,454,118.55	<b>375,859,454,118.55</b>
Өмчид гарсан өөрчлөлт		5,407,817,300.00		<b>5,407,817,300.00</b>
<b>2023 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл</b>	<b>94,487,644.09</b>	<b>5,876,231,609.00</b>	<b>402,956,300,887.34</b>	<b>694,806,616,678.53</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>770,466,910,961.86</b>	<b>1,173,768,433,481.55</b>
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	770,186,168,773.95	1,170,865,174,657.83
	Татаас, санхүүжилтийн орлого		
	Бусад мөнгөн орлого	280,742,187.91	2,903,258,823.72
1.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>464,849,251,784.68</b>	<b>588,725,746,145.94</b>
	Ажиллагчдад төлсөн	6,155,065,414.54	11,434,182,175.18
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,452,180,000.00	3,328,312,315.68
	Бараа материал худалдан авахад төлсөн	184,356,552,182.00	868,118,931.00
	Ашиглалтын зардалд төлсөн	13,780,050.43	560,820,547.25
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	17,946,071.00	162,848,901,824.34
	Хүүгийн төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	213,074,441,300.74	120,319,620,388.73
	Даатгалын төлбөрт төлсөн	4,473,251.00	
	Бусад мөнгөн зарлага	59,774,813,514.97	289,365,789,963.76
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>305,617,659,177.18</b>	<b>585,042,687,335.61</b>

2.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>816,001,541.33</b>	<b>1,080,208,252.95</b>
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүгийн орлого	816,001,541.33	1,080,208,252.95
2.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>0.00</b>	<b>1,923,540,246.00</b>
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		1,916,390,246.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд		7,150,000.00
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>816,001,541.33</b>	<b>-843,331,993.05</b>
3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	-	-
3.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>33,538,691,680.26</b>	-
	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	33,538,691,680.26	
3.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>12,921,675,868.01</b>	<b>278,094,537,258.86</b>
	Зээл авсан, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
	Төлсөн ногдол ашиг	12,921,675,868.01	278,094,537,258.86
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>20,617,015,812.25</b>	<b>(278,094,537,258.86)</b>
4.1	<b>Валютын ханшийн зөрүү</b>		<b>3,781,073,259.66</b>
4.2	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>327,050,676,530.76</b>	<b>309,885,891,343.36</b>
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>81,489,047,068.65</b>	<b>408,542,723,599.41</b>
6	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>408,542,723,599.41</b>	<b>718,428,614,942.77</b>

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 оны гүйцэтгэл	2023 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	<b>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт /биетээр/</b>						
	Нүүрс олборлолт	мянган.төг	2,534.7	3,000.0	3,573.3	573.3	119.1%
	Нүүрс борлуулалт	мянган.төг	2,800.2	3,000.0	3,117.6	117.6	103.9%
	Үүнээс: Экспорт	мянган.төг	2,660.5	2,900.0	2,543.8	(356.2)	87.7%
	Дотоод	мянган.төг	139.7	100.0	573.8	473.8	573.8%
	Хөрс хуулалт	мянган.м3	10,828.7	27,000.0	15,352.8	(11,647.2)	56.9%
	Нийт уулын цул	мянган.м3	12,639.2	29,142.9	17,848.5	(11,294.3)	61.2%
2	<b>Нийт борлуулалт /үнийн дүнгээр/</b>						
	Цэвэр борлуулалт	мянган.төг	765,561,741.5	1,244,498,400.0	1,096,282,742.7	(148,215,657.3)	88.1%
	Бусад орлого	мянган.төг	988,165.5	5,530,710.0	1,080,208.3	(4,450,501.7)	19.5%
3	<b>Нийт зардал</b>	<b>мянган.төг</b>	<b>298,214,548.6</b>	<b>1,055,529,588.1</b>	<b>592,432,951.9</b>	<b>(463,096,636.2)</b>	<b>56.1%</b>

	Үүнээс: а.Үндсэн үйлдвэрлэл	мянган.төг	289,839,977.4	692,848,815.7	217,376,687.0	(475,472,128.7)	31.4%
	б. Ерөнхий ба удирдлагын зардал	мянган.төг	4,839,881.8	362,680,772.4	359,366,861.3	(3,313,911.1)	99.1%
	в.Үйл ажиллагааны бус зардал	мянган.төг	3,534,689.4	-	15,600,305.9	15,600,305.9	-
	г. Ханшийн зөрүүний олз гарз	мянган.төг			(991,110.5)	(991,110.5)	
<b>4</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг /ТТӨА/</b>	<b>мянган.төг</b>	<b>433,808,501.2</b>	<b>194,784,049.8</b>	<b>504,929,999.1</b>	<b>310,145,949.3</b>	<b>259.2%</b>
<b>5</b>	<b>Цэвэр ашиг</b>	<b>мянган.төг</b>	<b>326,180,138.3</b>	<b>146,774,641.5</b>	<b>375,859,454.1</b>	<b>229,084,812.6</b>	<b>256.1%</b>
<b>6</b>	<b>Төсөвт төлөх нийт төлбөр</b>	<b>мянган.төг</b>	<b>291,982,056.3</b>	<b>247,935,701.3</b>	<b>283,520,905.2</b>	<b>35,585,203.9</b>	<b>114.4%</b>
	Үүнээс: АМНАТөлбөр	мянган.төг	179,972,992.6	176,498,875.0	147,162,887.8	(29,335,987.2)	83.4%
	Орлогын албан татвар	мянган.төг	107,628,362.9	47,724,880.5	129,070,545.0	81,345,664.5	270.4%
	Бусад/9 төрөл/	мянган.төг	4,380,700.9	23,711,945.8	7,287,472.4	(16,424,473.3)	30.7%
<b>7</b>	<b>Ногдол ашиг хуваарилалт</b>	<b>мянган.төг</b>	<b>291,280,688.2</b>	<b>124,758,445.3</b>	<b>263,115,339.2</b>	<b>138,356,893.9</b>	<b>210.9%</b>
	Үүнээс: Орон нутаг	мянган.төг	148,553,151.0	63,626,807.1	134,188,823.0	70,562,015.9	210.9%
	Бусад ХЭ	мянган.төг	142,727,537.2	61,131,638.2	128,926,516.2	67,794,878.0	210.9%
<b>8</b>	<b>Хөрөнгө оруулалт</b>	<b>мянган.төг</b>	<b>-</b>	<b>37,568,500.0</b>	<b>11,359,224.0</b>	<b>(26,209,276.0)</b>	<b>30.2%</b>
<b>9</b>	<b>Нийт авлага</b>	<b>мянган.төг</b>	<b>24,557,283.3</b>	<b>-</b>	<b>66,403,332.2</b>	<b>-</b>	<b>-</b>
	Үүнээс: Борлуулалтын авлага	мянган.төг	-	-	57,279,955.0	-	-
	Бусад авлага	мянган.төг	-	-	9,123,377.2	-	-
<b>10</b>	<b>Нийт өр төлбөр</b>	<b>мянган.төг</b>	<b>138,145,450.1</b>	<b>138,145,450.1</b>	<b>452,443,814.9</b>	<b>314,298,364.8</b>	<b>327.5%</b>
	Богино хугацаат өр төлбөр	мянган.төг	138,145,450.1	138,145,450.1	452,443,814.9	314,298,364.8	327.5%
	Урт хугацаат өр төлбөр	мянган.төг	-	-	-	-	0.0%
<b>11</b>	<b>Төлсөн татвар, хураамж нийт дүн</b>	<b>мянган.төг</b>	<b>291,982,056.3</b>	<b>247,935,701.3</b>	<b>283,520,905.2</b>	<b>35,585,203.9</b>	<b>114.4%</b>
<b>12</b>	<b>Нийт ажиллагсдын тоо</b>	<b>хүн</b>	<b>239</b>	<b>407</b>	<b>286</b>	<b>(121.0)</b>	<b>70.3%</b>
<b>13</b>	<b>Нийт цалингийн сан</b>	<b>мянган.төг</b>	<b>8,331,907.1</b>	<b>14,949,578.3</b>	<b>13,790,392.4</b>	<b>(1,159,185.9)</b>	<b>92.2%</b>
<b>14</b>	<b>Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал</b>	<b>төгрөг</b>	<b>0.39</b>	<b>0.85</b>	<b>0.54</b>	<b>(0.31)</b>	<b>63.7%</b>
<b>15</b>	<b>1 тонн нүүрсний ашиг</b>	<b>төгрөг</b>	<b>116,485.0</b>	<b>48,924.9</b>	<b>120,560.5</b>	<b>71,635.6</b>	<b>246.4%</b>
<b>16</b>	<b>Ашгийн хувь</b>	<b>хувь</b>	<b>42.6%</b>	<b>11.8%</b>	<b>34.3%</b>	<b>-</b>	<b>290.7%</b>
<b>17</b>	<b>Хөрс хуулалтын коэффициент</b>	<b>м3/тонн</b>	<b>4.3</b>	<b>9.0</b>	<b>4.3</b>	<b>-</b>	<b>47.7%</b>

## **Гурав. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар 12,624.8 сая төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

*Залруулсан алдаа:*

- Тайлант оны 2,151.5 сая төгрөгийн бусад орлогыг, үндсэн үйл ажиллагааны орлогоор тайлагнасан,
- Орлогын дэлгэрэнгүй тайлангийн борлуулсан бүтээгдэхүүний өртгийг ерөнхий журнал руу хөөн шалгахад 10,473.3 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", санхүүгийн тайлангийн ангилал болон толилуулга батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Аудитаар 198,387.3 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 6.9 сая төгрөгийн төлбөрийн акт, 185,186.3 сая төгрөгийн албан шаардлага, 13,194.1 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

### **5.1 Төлбөрийн акт**

1. Тайлант хугацаанд 1 албан хаагчид ажил хавсран гүйцэтгэсэн нэмэгдэлд 1.8 сая төгрөгийг эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

1. Албан хаагчдын ажил хавсарсан нэмэгдлийг түүвэрлэн шалгахад 7 албан хаагчид 5.1 сая төгрөгийн нэмэгдэл илүү тооцож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

### **5.2 Албан шаардлага**

1. Өмнөх 2021 оны санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар өгсөн албан шаардлагын дагуу тамирчин гэсэн орон тоонд ажиллаж байгаад чөлөөлөгдсөн 3 тамирчинд дахин өөр албан тушаалд томилон 16.3 сая төгрөгийн цалин олгосон ба тухайн байгууллагад ажил гүйцэтгэсэн эсэх нь нотлогдохгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

2. Тайланд тусгасан авлагын үлдэгдлийг түүвэрлэн шалгахад тайлант оны 47,182.2 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.3.1-д "анхан шатны баримт бүрдүүлэх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө

хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3. Тайланд тусгасан өглөгийн үлдэгдлийг түүвэрлэн шалгахад тайлант оны 137,277.8 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.3.1-д "анхан шатны баримт бүрдүүлэх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

4. Өмнөх аудитаар авлагын үлдэгдэл баталгаажуулаагүй, үйл ажиллагаа нь зогссон банкнудаас авах авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулаагүй, ханшийн тэгшитгэл хийгээгүй, эзэн холбогдогч нь тодорхойгүй ногдол ашгийн өглөгийн үлдэгдлийг баталгаажуулж ажиллах тухай өгсөн зөвлөмжийг биелүүлээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д "Шалгагдагч этгээд болон аудитад хамрагдагч дараах үүрэгтэй", 16.1.6-д "хуульд заасан бусад үүрэг", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

5. Тайлант оны дотоодын борлуулалтын орлогыг түүвэрлэн шалгахад 104.7 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, 49.7 сая төгрөгийн авлагыг, өглөгөөр буруу тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.3.1-д "анхан шатны баримт бүрдүүлэх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

6. Тайланд дутуу бүртгэсэн 109.9 сая төгрөгийн борлуулалтын орлогыг аудитын явцад залруулаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3 "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

7. Харилцахын баримтаас мөнгөн хөрөнгийн зарцуулалтыг түүвэрлэн шалгахад төсвийн болон төрийн бус байгууллага, хувь хүнд 100.0 сая төгрөгийн дэмжлэг, хандив олгосон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.21-д "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хөрөнгөөр хандив, тусламж,

*түүнтэй адилтгах аливаа хөтөлбөр, арга хэмжээ, нийгмийн шинжтэй үйл ажиллагаа, төсвийн алдагдлыг санхүүжүүлэхийг хориглоно*" гэж заасантай нийцээгүй байна.

8. Санхүүгийн СИ ТИ ЭС программын үнэнд шилжүүлсэн 19.9 сая төгрөгийг шууд зардлаар бүртгэсэн байна.

Энэ нь НББОУС-1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д *"үнэн зөв байх"*, 20 дугаар зүйлийн 20.2.3-д *"холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах"*, 20.2.4-д *"нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах"* гэж заасантай тус тус нийцээгүй байна

9. "Анкерхаус ХХК-д "Гэрэлтүүлгийн ажил" гүйцэтгэсэн зардлыг олгохдоо магадлашгүй ажлын зардал 3.4 сая төгрөг, захиалагчийн албаны зардал 2.1 сая төгрөг, АНДГАЙ ХХК-д "Уурхайд автомашины хучлагын тавцангийн ажил"-д захиалагчийн албаны зардал 2.2 сая төгрөгийг тус тус холбогдох гэрээ, баримт бичиг, акт зэргийг үндэслэн шилжүүлээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоол *"Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг, төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"*-ын 4 дүгээр зүйлийн 4.2.2.5-д *"төсөл, арга хэмжээний техник, технологийн хяналтын зардал болох захиалагчийн хяналт, зохиогчийн хяналтын зардлыг захиалагчийн техник хяналтын дансанд, чанарын баталгаат хугацааны барьцаа буюу ашиглалтад тохируулах, зүгшрүүлэх хугацааны санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд, зураг төслийн үнэ, нормчлолын сангийн зардлыг тус тусын дансанд холбогдох гэрээ, баримт бичиг, акт зэргийг үндэслэн шилжүүлэх"* гэж заасантай нийцэхгүй байна.

10. Шатахуун зарцуулалтыг түүвэрлэн шалгахад Lexus-570, 00-05 ӨМА 17.6 сая төгрөг, Toyota pruis-30 27-58 УБӨ- 0.5 сая төгрөг, Land Cruiser-200, 50-55 ӨМЭ 3.9 сая төгрөг, Land Cruiser-200, 93-22 ӨМҮ 4.3 сая төгрөгийн шатахууны норм, норматив хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын *"Жишиг норм батлах тухай"* тушаалын 1 дүгээр хавсралт *"Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"*, 2 дугаар хавсралт *"Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болох бууруулах нөхцөлүүд"* гэж заасантай нийцэхгүй байна.

11. "Уурхайд автомашины хучлагын тавцан байгуулах ажил"-ын 129.7 сая төгрөгийн гэрээний үнийн дүнгээс барьцаа болох 5 хувь болох 6.4 сая төгрөг суутгаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.6 -д *"Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаат болон зүгшрүүлэх тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг уг хугацаа дуустал барьцаалах нөхцөлийг захиалагч тендерийн баримт бичигт тусгаж болно"* гэж заасантай нийцэхгүй байна.

12. Харилцахаас шилжүүлсэн гүйлгээг түүврийн аргаар тулган баталгаажуулахад хөрс хуулалтын гэрээтэй 5 ААН-тэй нэмэлт гэрээ байгуулснаас 2 ААН-ийн 2,768.8 сая төгрөгийг хөрс хэмжилтийн актад маркшейдер инженер гарын үсэг зураагүй байхад шилжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Байгаль орчны хяналт шинжилгээний ажил, Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах, бэлчээрийн судалгаа, малчдын амьжиргааг чадавхжуулах төсөл боловсруулах, худаг гаргах, трактор, тракторын дагалдах хэрэгсэл худалдах авах, нөөцийн тодотгол тайлан боловсруулах гэсэн 1,073.0 сая төгрөгийн ажлууд гэрээний хугацаанд бүрэн хэрэгжээгүй, бараа, ажил үйлчилгээг хүлээж аваагүй байна. Энэ нь Иргэний хуулийн 343 дугаар зүйлийн 343.2-д "Ажил гүйцэтгэх гэрээний зүйл нь гүйцэтгэсэн ажлын үр дүн байна", 358 дугаар зүйлийн 358.1-д "Ажил гүйцэтгэх тодорхой төрлийн бүх гэрээнд энэ бүлгийн холбогдох заалтууд нэгэн адил хамаарна" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн өмчийн хөрөнгийн хяналтыг сайжруулах, гэрээний үүргийн биелэлтийг хангуулах, холбогдох арга хэмжээг авч ажиллах

2. Тайлант онд бүртгэсэн зарим бүртгэлийг НБББББ-д тусгагдаагүй байгаа тул бодлогын баримт бичгийг шинэчлэх шаардлагатай байна.

Өгсөн зөвлөмж: Бизнес төлөвлөгөөнд НБББББ-г шинэчлэх талаар тусгах

3. "Төслийн барилга байгууламж, сэргээгдэх эрчим хүч, хөв цөөрмийн зураг төсөл боловсруулах" ажлын гэрээ дүгнэн санхүүжилтийг бүрэн олгосон боловч 168.9 сая төгрөгийн зураг төсвийг хөрөнгөд бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Зураг төсвийн бүртгэлд тусгах

4. Улаанбаатар хот дахь төлөөлөгчийн газрын албан хаагчдад цалин хөлс олгохдоо цаг ашиглалтын бүртгэл, ажлын цагийн бүртгэлийг хөтлөөгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажил гүйлгээ хийж хэвших

5. Жолоочийн тооцооны хуудсыг үнэн зөв, батлагдсан маягтын дагуу хөтлөөгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эрх бүхий байгууллагаас баталсан анхан шатны маягтыг үнэн зөв хөтөлж байх

6. Капитрон банкны харилцахад 09 дүгээр сарын 05 өдрөөс 13 өдрийн хооронд 6,274.6 сая төгрөгийн 16 гүйлгээг хоёрдугаар гарын үсэггүй хийсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 "аж ахуйн нээж, байгууллагын хөрөнгийн орлого, зарлагын баримт болон санхүүгийн тайланд хоёрдугаар гарын үсэг зурах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хариуцсан албан тушаалтан өөрчлөгдөхөд ажил хүлээлцэх асуудлыг байгууллагын удирдлага зохион байгуулж байх, анхан шатны бүрдэл дутуу баримтаар хөрөнгө мөнгө зарцуулахгүй байх

7. Харилцахын баримтыг анхан шатны баримттай түүвэрлэн тулган шалгахад байгууллагын дотоод журмаар олгосон нэг удаагийн тэтгэмж 49.0 сая төгрөгөөс 4.9 сая төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутгаагүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6-д "үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого", Татварын ерөнхий газрын даргын 2019 оны А/261 дугаар тушаалаар баталсан "Хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөх, албан татварын хөнгөлөлт эдлүүлэх журам"-ын 2.2 "Суутгаан төлөгч нь хууль тогтоомжид тусгайлан заагаагүй "Хөдөлмөрийн дотоод журам" зэрэг зөвхөн тухайн байгууллагын баримт бичиг, шийдвэрийг үндэслэн олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламжийг албан татвараас чөлөөлөхгүй" гэсэн заалттай тус тус нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын баримт бичиг, шийдвэрийг үндэслэн олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламжаас албан татвар суутгаж байх

8. Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй нийт 207 ширхэг үндсэн хөрөнгө байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн шийдвэрлүүлж байх

9. Урьдчилж төлсөн зардал дансанд тайлант жилд зардлаар хүлээн зөвшөөрөх тусламж дэмжлэг, гидрийн шингэн, зөөврийн компьютерын үнэ, машин засвар үйлчилгээ, ажлын хөлс, хөрс хуулалт, ажлын төлбөр, тооцоо, коктейлийн үнэ тэмцээний зардлуудыг бүртгэж, тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бүртгэлийг үнэн зөв бодитой тайлагнах

10. Тайлант оны зарлагын үр ашгийн тооцоогоор төлөвлөсөн үндсэн үйлдвэрлэлийн зардал, удирдлагын зардал, үндсэн үйлдвэрлэлийн бус зардлууд нь гүйцэтгэлээр зөрүүтэй тусгагдсан байна. Энэ нь НББОУС-1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "*холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах*" гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Биржийн болон хил нөхцөлөөр нүүрс борлуулж эхэлсэнтэй холбоотой өөрчлөлтийг зарлагын үр ашгийн тооцоололд бодитой төлөвлөх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



2	Албан хаагчдын ажил хавсарсан нэмэгдлийг түүвэрлэн шалгахад 7 албан хаагчид нэмэгдэл илүү тооцож олгосон	1	5,083.8	1	5,083.8			-	-	-	-	-	-
3	Өмнөх 2021 оны санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар өгсөн албан шаардлагын дагуу тамирчин гэсэн орон тоонд ажиллаж байгаад чөлөөлөгдсөн 3 тамирчныг дахин өөр албан тушаалд томилон цалин олгосон	1	16,370.3			1	16,370.3			-	-	-	-
4	Тайлант онд үүссэн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй	1	47,182,220.9	-	-	1	47,182,220.9			-	-	-	-
5	Тайлант онд үүссэн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй	1	137,277,875.7	-	-	1	137,277,875.7			-	-	-	-
6	Өмнөх аудитаар авлагын үлдэгдэл баталгаажуулаагүй, үйл ажиллагаа нь зогссон банкнудаас авах авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулаагүй, ханшийн тэгшитгэл хийгээгүй, эзэн холбогдогч нь тодорхойгүй ногдол ашгийн өглөгийн үлдэгдлийг баталгаажуулж ажиллах тухай өгсөн зөвлөмжийг биелүүлээгүй	1	0	-	-	1	0			-	-	-	-
7	Тайлант оны дотоодын борлуулалтын орлогыг түүвэрлэн шалгахад 104,8 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, 49,7 сая төгрөгийн авлагыг өглөгөөр буруу тайлагнасан	1	154,529.1	-	-	1	154,529.1			-	-	-	-
8	Дутуу бүртгэсэн 109.1 сая төгрөгийн борлуулалтын орлогыг аудитын явцад залруулаагүй	1	109,922.2	-	-	1	109,922.2			-	-	-	-
9	Харилцахын баримтаас түүвэрлэн шалгахад 18 төсвийн болон төрийн бус байгууллага, хувь хүнд дэмжлэг, хандив олгосон	1	100,000.0	-	-	1	100,000.0	-	-	-	-	-	-
10	Санхүүгийн СИ ТИ ЭС программыг шууд зардлаар бүртгэсэн	1	19,900.0			1	19,900.0						
11	Шатахуун зарцуулалтыг түүвэрлэн шалгахад шатахууны норм, норматив хэтрүүлэн зарцуулсан	1	26,488.8			1	26,488.8						

12	НБББББ-д тусгагдаагүй ажил гүйлгээ бүртгэсэн	1	0					1	0			
13	Төслийн барилга байгууламж, сэргээгдэх эрчим хүч, хөв цөөрмийн зураг төсөл боловсруулах" ажлын гэрээ дүгнэн санхүүжилтийг бүрэн олгосон боловч зураг төсвийг хөрөнгөд бүртгээгүй	1	168,923.0					1	168,923.0			
14	Улаанбаатар хот дахь төлөөлөгчийн газрын албан хаагчдад цалин хөлс олгохдоо цаг ашиглалтын бүртгэл, ажлын цагийн бүртгэлийг хөтлөөгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн	1	0					1	0			
15	Жолоочийн тооцооны хуудсыг үнэн зөв, батлагдсан маягтын дагуу хөтлөөгүй	1	0					1	0			
16	Капитрон банкны харилцахад 09 дүгээр сарын 05-13-ны хооронд 16 гүйлгээг хоёрдугаар гарын үсэггүйгээр хийсэн	1	0					1	0			
17	Дотоод журмаар олгосон нэг удаагийн тэтгэмжээс хувь хүний орлогын албан татвар суутгаагүй	1	4,900.0					1	4,900.0			
18	Хөрс хуулалтын гэрээтэй 5 ААН-тэй нэмэлт гэрээ байгуулан хугацаа дууссанаас хойш 2 ААН-ийн 2,768,8 сая төгрөгийг хөрс хэмжилтийн актад маркшейдер инженер гарын үсэг зураагүй байхад шилжүүлсэн	1	0			1	0					
19	Урьдчилж төлсөн зардал нь өмнөх оноос үлдэгдлээс 11 дахин өссөн нь тооцоо нийлж баталгаажуулаагүй тайланд жилд зардлаар хүлээн зөвшөөрөх тусламж дэмжлэг, гидрийн шингэн, зөөврийн компьютерын үнэ, машин засвар үйлчилгээ, ажлын хөлс, хөрс хуулалт, ажлын төлбөр, тооцоо, коктейлийн үнэ тэмцээний зардлуудыг тусгасан	1	11,914,311.5					1	11,914,311.5			
20	Үндсэн хөрөнгөд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй 207 ширхэг хөрөнгө байна.	1	0					1	0			



		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаал тны тоо	Тоо	Дүн
<b>Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>													
1	Хөрсний бохирдол бууруулах био 00-р хангах ажил"-ын хүрээнд Цогтцэций, Номгон сумын зорилтод бүлгийн гэр хорооллын айл өрхөд 78,426.4 мянган төгрөгөөр 9 ширхэг Эко жорлон барьсан	1	78,426.4			1	78,426.4						
2	"Нүүрсний хайгуул, судалгааны ажлын өрөмдлөг хийж гүйцэтгэх", "Ус нөөцлөх сав" гэсэн ажлуудад 99,974.2 мянган төгрөгийн нэмэлт гэрээ байгуулсан,	1	99,974.2			1	99,974.2						
3	Тухайн онд худалдан авсан барааг цахим дэлгүүрт байршуулах хүсэлт гаргаагүй, нийт 106,220.1 мянган төгрөгийн өртөгтэй 31 ширхэг компьютер, тоног төхөөрөмж, техник хэрэгслийг шууд худалдан авсан	1	106,220.1			1	106,220.1						
4	Тус компани автомашин, тээврийн хэрэгслүүд тод өнгийн дэвсгэр өнгө бүхий улсын дугааргүй	1						1					
5	Өвс худалдан авах" ажлын гэрээг 2023 оны 12 сарын 09-ны өдрөөс 14 хоногийн хугацаатай байгуулсан боловч гэрээний хугацаанд хэрэгжээгүй	1	32,880.0					1	32,880.0				
<b>Дүн</b>		<b>5</b>	<b>317,500.7</b>			<b>3</b>	<b>284,620.7</b>	<b>2</b>	<b>32,880.0</b>				
<b>Шилэн данс тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>													
1	Гэрээ хэлцэл байгуулах, захиргааны шийдвэр гаргах, хөрөнгө зарцуулахдаа ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг хөтөлж шилэн дансанд байршуулаагүй	1	0					1	0				
<b>Дүн</b>		<b>1</b>	<b>0</b>					<b>1</b>	<b>0</b>				
<b>Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>													

1	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 22 дугаар тогтоолд Сул коксжих нүүрс буюу 1/3 коксжих нэг тонн нүүрсний үнэ 55 /ам.доллар/ байхаар баталсан нь Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 08 дугаар сарын 26- ны өдрийн хурлын шийдвэртэй зөрүүтэй	1				1						
2	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 07 дугаар сарын 18 дугаар тогтоолд нэг тонн коксжих нүүрсний үнийг 96.00 /ам.доллар/ байхаар баталсан нь Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 07 дугаар сарын 21-ны өдрийн хурлын шийдвэртэй зөрүүтэй	1						1				
3	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн хурлаар Дэгдэмхий бодис дунд коксжих нүүрсийг Ханбогд сумын Цагаан хад болон Гашуун сухайт дахь Гаалийн хяналтын талбай хүргэх нөхцөлөөр үнийг 105 доллар байхаар хэлэлцэж шийдвэрлэсэн. Гэтэл тус хурлаар хэлэлцэгдээгүй Дэгдэмхий бодис дундаас их, хийн нүүрс /4 дүгээр давхарга/ 1/3 сул коксжих нүүрс гэсэн 2 нэр төрөл/ангиллын нүүрсний үнийг баталсан	1				1						
4	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн 04 дүгээр тогтоолын үндэслэх хэсэгт "Тавантолгой" ХК болон Үйлдвэрчний Эвлэлийн Хорооны "Хамтын гэрээ"-ний 2.5 дахь заалтыг үндэслэсэн байна. Тус хамтын гэрээнд 2.5 дахь заалт байхгүй	1				1						
5	Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолын хэвлэмэл хуудсыг баталгаажуулаагүй	1				1						
6	Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолын хэвлэмэл хуудсыг индексжүүлээгүй	1						1				
7	Хуралд оролцоогүй зөвлөлийн гишүүнээр тухайн хурлын тэмдэглэлд гарын үсэг зуруулсан	1						1				

8	Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолыг оны эхнээс дугаарлаагүй, 29, 30, 31 ,32 гэсэн дугаар давхардаж байна. Мөн 2023 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 32 дугаар тогтоол, 2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 30 дугаар тогтоолыг ирүүлээгүй, баримт бичгийн архивын нэгж болгоогүй	1						1				
9	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 21 дүгээр тогтоолын захирамжлах хэсэг тодорхойгүй, 29 дүгээр тогтоолын захирамжлах хэсгийн заалтыг буруу дугаарласан	1						1				
10	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 09 дүгээр тогтоолоор компанийн гүйцэтгэх удирдлагыг ажлаас чөлөөлж, гүйцэтгэх захирлыг томилсон,10 дугаар тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг чөлөөлж, томилсон	1						1				
11	2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 31, 32 дугаар тогтоолд байгууллагын тэмдэг дарж баталгаажуулаагүй	1				1						
12	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 14 дүгээр тогтоолын хавсралтаар гэрээ байгуулах эрх олгосон компаниудыг хавсралтаар баталсан боловч тогтоолын хавсралт байхгүй	1						1				
<b>Дүн</b>		<b>12</b>				<b>5</b>		<b>7</b>				
<b>Нийт дүн</b>		<b>42</b>	<b>198,387,311.6</b>	<b>2</b>	<b>6,955.8</b>	<b>20</b>	<b>185,186,249.6</b>	<b>20</b>	<b>13,194,106.3</b>			

